

БАТЛАВ.  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭЛНИЙБОДЛОГЫН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Ц. УРАНБЯМБА



**“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР-2022” АЯНЫ ХҮРЭЭНД  
ЕБС-ИЙН СУРАГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
“ИХ СОРИЛГО-2022” УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Мандалговь хот

2022.04.04

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ:** Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн зорилго нь монгол бичгийн сургалтыг суурь боловсролын агуулгад багтаан зохион байгуулж бүх нийтийг сургах монгол бичгийг хэрэглэх орчин бий болгоход оршино.

Монгол хэл, үндэсний бичгийн уралдаанд аймгийн төвийн ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулснаар эх хэл, үндэсний бичгээрээ зөв сайхан бичих, унших, зохион найруулах улмаар үндэсний бичгээрээ бахархах, түүнийг танин мэдэх, бусдад сурталчлах давуу талтай байх болно.

**ХОЁР: ЗОРИЛГО:** Дундговь аймгийн ЕБС-ийн багш, сурагчдын эх хэл, бичиг соёлоо сурч судлах, хамгаалах, хөгжүүлэх, өвлөх үйл хэрэгт оруулах хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлж, үндэсний бичгийн боловсролыг чанаржуулах, сурах хүсэл сонирхлыг өдөөх, хөхиүүлэн дэмжих, урамшуулахад оршино.

**ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ:** Дундговь аймгийн ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчид

**ДӨРӨВ: ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:** Аймгийн ХБСЗ, БСУГ, аймгийн Төв номын сан, ЕБС-ууд

**ТАВ: ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР, ХУГАЦАА:** Сорилго, уншлага- Цэгц Билиг сургууль дээр 2022 оны 04 сарын 28-ны 15 цагаас эхэлнэ

**ЗУРГАА: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** Сорил, уншлага- 6-12-р анги, Уншлагын уралдааныг номын 50 хувиар сугалуулж уншуулна

- ✓ 6-7 -р анги: Уншлагын сурах бичиг хуудас 34-66
- ✓ 8-р анги: Таван эрдэнэ хуудас 3-35-р хуудас
- ✓ 9-р анги: Тод мөр хуудас 3-31 хуудас
- ✓ 10-12-р анги: Арга билиг хуудас 3-33

Уншлага болон сорилыг тухайн ангид хичээл заадаггүй багш, хянагч багшийн хамт авна. Сурагчдын материалыг шифрлэж, нууцлалыг баримтална.

**ДОЛОО: ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ, ШАГНАЛ**

**Сурагчдыг шагнах журам :** Уралдааны ангилалд 6-12-р ангийн сурагчид оролцох бөгөөд сорилго болон уншлагын нийлбэр оноогоор эхний 6 сурагчийг шагнаж урамшуулна. Үүнд:

**Тэргүүн байр-1**

**Дэд байр-2**

**Гутгаар байр- 3 сурагчийг шалгаруулж, медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал**

**Багш нарыг шагнах журам :** Багш нарыг сурагчдын амжилтаар эхний 3 байр эзлүүлж, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

**Сургуулийг шагнах журам:** Сурагчдын амжилтаар шалгарсан нэг сургуулийг өргөмжлөл, цомоор шагнаж урамшуулна.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭЛНИЙ БОДЛОГЫН САЛБАР ЗӨВЛӨЛ  
САЙНЦАГААН СУМЫН ЦЭГЦ БИЛИГ СУРГУУЛЬ**